



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 352

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний Нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 54,000,000.00 (тавин дөрвөн сая) төгрөгийн балансын үнэ, 15,750,000.00 (арван таван сая долоон зуун тавин мянган) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Улсын ерөнхий прокурорын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Иргэний Нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Улсын Ерөнхий Прокурорын газрын улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Тамгын газрын дарга Ц.Арвинбуудай нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ГАВАА



Төрийн үеийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн
853 дугаар тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРААС УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАРТ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Киа Оптима, 18-18 УБТ, GT411BG5093870, Суудлын автомашин	2016/2017	1593	54,000,000.00	15,750,000.00	38,250,000.00
НИЙТ ДҮН				54,000,000.00	15,750,000.00	38,250,000.00

(гөгрөг)

(арван таван сая долоон зуун тавин мянган)

(тавин дөрвөн сая)

(гучин найман сая хоёр зуун тавин мянган)